

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 03 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2019 оны 04 дүгээр сарын 01

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 03 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:**



Тайлангийн хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 1249 ширхгийг шинээр хэвлэн, 126 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 16 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 724 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 203 иргэний мэдээллийг цахим архивт оруулсан байна. Мөн гадаадын гурван иргэнд регистрийн дугаар олгосон. Үйлчилгээний танхимд 980 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авчээ. Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд 10 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, 10 аж ахуйн нэгж, байгууллагын 12 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг шийдвэрлэлээ. Нийт 2238 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1786, биечлэн 452 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын хоёр мэргэжилтэн ажиллаж 98 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 28 иргэнд визийн зөвшөөрөл, 29 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 76 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 14 иргэний ангиллыг сольж, 4 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 60 иргэнд зохих ангиллын виз олгосон байна.

2019 оны 03 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад виз олголт 18.1 хувиар, хувийн урилга олголт 18.8 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 13.7 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 66.0 хувиар, түр ирэгчийн хасалт 15.4 хувиар, визийн сунгалт 16.2 хувиар тус тус өссөн, харин визийн зөвшөөрөл олголт 0.6 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 16.6 хувиар, түр ирэгчийн бүртгэл 5.3 хувиар тус тус буурсан байна.


Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэг удаагийн зарлигаар харьяалалгүй гурван хүн Монгол Улсын харьяат болж, дөрвөн удаагийн зарлигаар 104 иргэн Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 25 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан таван иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлээ.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 26 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3070 иргэн бүртгэлтэй байна.



Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан есөн олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 03 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 95 төрийн бус байгууллага байна.

Гадаад улсын хоёр гэр бүлд үрчлүүлсэн зургаан хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

## 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн найман улсын 13 иргэнийг байгууллагын даргын 12 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын даргын тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан нэг гадаадын иргэний Монгол Улсаас албадан гаргасан тушаалыг хугацаанаас өмнө цуцалсан.


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар нэг улсын гурван иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, дөрвөн удаагийн тушаалаар гурван улсын дөрвөн иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу 89 гадаадын иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй 10 гадаадын иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаажээ.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг 10 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн нэг захирамжаар гадаадын нэг иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр нэг иргэнд гарах сануулга өгсөн байна.



Тайлангийн хугацаанд хоёр удаагийн төлөвлөгөөт, 15 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 48 аж ахуйн нэгж, байгууллага, 104 гадаадын иргэнийг хамруулсан ба 61 гадаадын иргэн, 66 аж ахуйн нэгж, байгууллага /176 гадаадын иргэн/, дөрвөн уригч иргэн /дөрвөн гадаадын иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 178,130,000 /нэг зуун далан найман сая нэг зуун гучин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

2019 оны 03 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 94.1 хувиар өссөн, харин зөрчил гаргасан гадаадын иргэн 35.8 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 20.0 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 48.3 хувиар тус тус буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг нэгтгэн албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

2018 оны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайлангаас өгсөн зөвлөмжийн дагуу тус байгууллагаас үйлчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр 9 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ бүхий тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан баталлаа. Төлөвлөгөөг дотоод сүлжээгээр нийт албан хаагчдад хүргүүлэн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн захиргааны 114 албан хаагчдын нэмэгдэл хөлсийг шинэчилж байгууллагын даргын 2019 оны Б/61 дүгээр тушаалаар баталлаа.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл хуралдаж 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлав. Мөн Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд 119 албан хаагчийн мэдээллийг шинэчилж оруулсан.

Төрийн албан зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу байгууллагын дарга болон дэд даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим шуудангаар хүргүүллээ.

Албан хаагчдын мэдээллийн цагаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэслэгч, доктор, дэд профессор Ц.Минжин “Байгууллага ба хувь хүний харилцаа” сэдвээр мэдээлэл хийж 75 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг багц сургалтад” 17 албан хаагч, Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа албан хаагчдыг чадавхжуулах нь” сэдэвт сертификаттай сургалтад 32 албан хаагч тус тус хамрагдлаа.

Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “KOICA”-ын төслөөр хэрэгжиж буй “ORACLE DB” өгөгдлийн сангийн сертификаттай сургалтад Мэдээллийн технологийн хэлтсийн гурван албан хаагч, Удирдлагын Академийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг “Албан хэрэг хөтлөлт” сэдэвт зорилтод зайн сургалтад Захиргаа, удирдлагын газрын нэг албан хаагч тус тус хамрагдаж байна.

Төрийн албаны тухай хуультай холбогдуулан Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан нийт 17 журмыг эмхэтгэн, 2019 оны мэдээлэл сэтгүүлийг бэлтгэн 250 ширхэг хэвлүүлж, албан хаагчдад хүргүүлэв.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан видео танилцуулгыг англи, монгол хэлээр хийх зорилгоор “ЭЙЧ-ЭС-ЭН” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу холбогдох зураг авалтуудыг хийж найман минутын видео танилцуулгыг бэлтгэлээ.

Хан-Уул дүүргийн онцгой комиссын даргын 2019 оны 03 дугаар албан даалгаврын дагуу Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулилтыг зохион байгуулж, хамтран ажиллалаа.

Байгууллагын даргын 2018 оны А/107 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын газар, хэлтсээс архивт баримт хүлээн авах хуваарь”-ийн дагуу тайлангийн хугацаанд нийт 345 хадгаламжийн нэгжийг бүртгэлийн дагуу архивт хүлээн авч, сан хөмрөгийг нөхөн бүрдүүлсэн байна.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 57 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 42 өргөдөл шийдвэрлэгдэж, 15 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Байгууллагын даргын “Гадаад иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”-ыг 2019 оны А/80, “Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах тохиолдолд баримтлах заавар”-ыг А/94 дүгээр тушаалаар баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн “Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн төсөл”, “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгах саналыг тус тус боловсруулан албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

“Авлига албан тушаалтны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2019 онд хийх ажлын төлөвлөгөө”-г батлан ажиллалаа.

Шинээр томилогдохоор нэр дэвшсэн зургаа, шилжин томилогдохоор нэр дэвшсэн нэг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлж, шинээр томилогдсон 14, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн нэг албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулав.

Тайлангийн хугацаанд байгууллагын дарга Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Дэвид Спрул, Нэгдсэн үндэстний байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Монгол Улсыг хариуцсан захирлаар томилогдсон Жьюзеппе Кросет, “ДЭЗЭРЭТ” олон улсын энэрлийн байгууллагын Азийн бүсийн удирдагч Петер Флечер Мейрс нарыг тус тус хүлээн авч уулзан, цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Түүнчлэн Гадаадын иргэн, харьяатын газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын удирдлага хоорондын албан уулзалтыг Анкара хотноо энэ оны 04 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байгаатай холбогдуулан айлчлалын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

## 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Байгууллагын дотоод сүлжээний и-оффис систем ажиллаж байсан DELL R320 болон R710 серверүүдийг өндөр хурдны DELL R740XD серверт нэгтгэж шилжүүлснээр тус системийн аюулгүй байдал сайжирч, нэвтрэх хурд гурав дахин нэмэгдсэн.

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем /APP/-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “СИТА” компанийн төлөөлөгчидтэй 02 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд гэрээний төслийн хэлэлцээрийн уулзалтыг хийлээ. Тус уулзалтаар гэрээний төсөлтэй холбогдуулан тодруулга авч өөрчлөлт оруулах шаардлагатай заалтуудын талаар нэг бүрчлэн санал солилцож, уулзалтын дараа тухай бүр цахим шуудангаар харилцаж байна. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг бичгээр авах ажлыг 03 дугаар сарын 21-ний өдөр дуусгаж, нэгтгэх ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн “АРИНК” компанитай 02 дугаар сарын 21-ний өдөр хийсэн цахим хурлаар урьдчилан тохиролцсоны дагуу тэдний төлөөлөгчидтэй 03 дугаар сарын 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, компанийн зүгээс 03 дугаар сарын 25-ны өдөр гэрээний урьдчилсан төслийг ирүүлснийг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлэхээр ажиллаж байна.

#### 2.4. Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 02 дугаар сарын мэдээг Үндэсний аюулгүй байдлын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газраас өгсөн үүргийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2018 оны жилийн тайланг батлагдсан маягтын дагуу, төв болон орон нутаг дахь газруудын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлага, орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл зэргийг түүвэрлэн цахим шуудангаар хүргүүллээ.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хилээр 127 орны 61866 гадаадын иргэн хил нэвтэрснээс түүвэрчилж 1239 гадаадын иргэдийн хил нэвтрэлтэд хяналт тавихад Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй иргэний гарах-орох визгүй, гадаадын иргэний нэрийн мэдээллийг олон янзаар бүртгэсэн зэрэг зөрчил илэрснийг Хил хамгаалах байгууллагын холбогдох анги, салбарт хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн 2019 оны 02 дугаар сард хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчид виз, бүртгэлийн зөрчил бүхий долоон гадаадын иргэнийг тус байгууллагад шилжүүлэлгүйгээр улсын хил нэвтрүүлсэн тухай холбогдох мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газрын Боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх газарт албан бичгээр хүргүүлсэн.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл, зарим хилийн боомтын төлөвлөлт, Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2018 оны тайлан, 2019 оны төлөвлөгөөний талаар болон бусад асуудлаар хэлэлцсэн Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны нэгдүгээр хуралдаан болон Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн хуралд тус байгууллагын төлөөлөл оролцлоо.

#### 2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6.27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 03 дугаар сард 1.57 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 1.22 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан болно.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2019 оны 03 дугаар сарын байдлаар 788,6 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 159.3 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 31,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Тайлангийн хугацаанд “www.tender.gov.mn” цахим хуудсаар гурван тендер зарласнаас “Багаж техник хэрэгсэл”-ийн нээлттэй тендер шалгаруулалтад “Блүүнвейб” ХХК шалгарч гэрээ байгуулах албан бичгийн хүргүүлсэн бөгөөд “Нормын хувцас” худалдан авах тендер шалгаруулалтад “Амно Фейшн” ХХК, “Хос-Аз” ХХК, “Би энд Би Эс” ХХК, “Бат зүү” ХХК шалгарснаас “Хос-Аз” ХХК, “Би энд Би Эс” ХХК-тай худалдан авах гэрээ байгуулсан.

#### 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Ховд аймгийн долоон сумаас ирүүлсэн 10255 казах иргэдийг мэдээллийг байгууллагын мэдээллийн сан болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн

сантай тулгалт хийхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар харьяатаас гарсан 84 иргэний мэдээлэл давхардсан байсныг илрүүлсэн.

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Агаарын замын боомт хариуцсан газраас Тээврийн прокурорын газартай хамтран “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Дорноговь аймаг дахь газраас албаны барилга байгууламжийн аюулгүй байдал хангах зорилгоор хуучин аналог камерын системийг бүрэн шинэчлэн дуу дүрсний өндөр нягтрал бүхий хяналтын IP камерыг байршуулсан.

Мөн Булган боомтод шинээр барих албан хаагчдын байрны зураг төслийг “Алтайн газрын хүч” ХХК-иар хийлгэж, Ховд аймгийн Засаг даргад танилцуулснаар 2019 оны 04 дүгээр сард хуралдах аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад орууллаа.

Дорнод аймгийн Зүүн бүс дэх газраас “Дизерет” олон улсын энэрлийн байгууллагатай хамтран Эрээнцав боомтод ундны усны худаг гаргуулах асуудлаар хамтран ажиллах талаар тохиролцон, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргэсэн.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР